

**Орон хийдийн магтаал дахь зурхайн ухааны газрын шинжийн
өгүүлэмжүүд**

Магсаржавын ГАНХУЯГ*

Монгол Улс, Улаанбаатар,

Гандантэгчэнлин хийд

Received: Aug 19, 2024

Revised: Aug 25, 2024

Accepted: Oct 8, 2024

Хураангуй: Энэхүү өгүүлээр монголчуудын төвөд хэлээр зохиосон орон, хийдийн магтаалын хөгжилд оруулсан өвөрмөц нэгэн өгүүлэмж болох газрын шинжийг хэрхэн тусгасан тухай өгүүлэхийг зорилоо. Монголчууд эртнээс уламжилж ирсэн уламжлалт мэдлэг ухааны нэг газар шинжих уламжлалт ойлголт бөгөөд сав ертөнц болох газар орноо ихэс дээдс, нас нөгчсөн нэгнээ өлгий болох газар, малын бэлчээр, бууц бууриа сонгох, газар тариалан эрхлэх, хот балгад босгох, сүм дуган, суварга шүтээн барих газар орноо шинжиж ирсэн байдаг. Орон, хийд магтаалын шүлгүүдэд тухай хийд, орныг барихдаа бэлгэдлийн үүднээс мөн уламжлалт ахуй ёсны талаас эх бичиг сурвалжид тулгуурлан задлан шинжлэх нэгтгэн дүгнэх болон үзэгдлийн /феноминологи/ аргаар хэрхэн авч үзсэн талаар өгүүлэх юм.

Энэ өгүүлэлд монголчуудын төвөд хэлээр зохиосон орон, хийдийн магтаалд газрын шинжийг ерөнхийгөөс тодорхой руу хэрхэн уран яруугаар шүлэглэн магтаж байгааг тодорхой жишээн дээр авч үзүүлээ. Орон, хийдийн магтаалд газар шинжих уламжлалт мэдлэг, ухааныг уран яруугаар хэрхэн өгүүлсэн байна, гол шинжид ямар шинжийг илүүтэй чухалчилж байгааг тодруулж өнөө цагт хот суурин газрын монголчуудад таниулж мэдүүлэх нь чухал болжээ хэмээн үзэж байна. Газар шинжих мэдлэг ухаан нь өнөө цагт мартагдаж байгаа ч мөн орхиж болохгүй мэдлэг, ухааны нэг юм.

Түлхүүр үг: Газар шинжих, төвөд хэлт уран зохиол, Бурхны шашин

* © М.Ганхуяг 2024

Email: mgankhuyag@yahoo.com

Astrological Sayings of Geomancy in the Praises of Sacred Places and Monasteries

GANKHUYAG Magsarjav
Gandantegchenlin monastery,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: *In this article, I intend to study one of the features of the praise of sacred places and monasteries composed in the Tibetan language by Mongolian scholars. In Mongolian tradition, it is customary to assess the suitability of areas for graveyards, distinguishing between those for nobility and ordinary individuals, as well as for pasture land to support livestock. This assessment is integral to processes such as relocating, engaging in agriculture, and constructing cities, temples, and stupas.*

As we examine the praises of sacred places and monasteries, it is essential to understand the symbolic expressions contained within them. This involves analyzing the methodologies employed and summarizing the findings from various sources. This article provides a specific example demonstrating how the features of the land are eloquently praised, progressing from general to specific, in the Tibetan-language praises of sacred places and monasteries composed by Mongolian scholars.

Understanding how traditional knowledge and the science of geomancy are described in these praises is an important area of study. Identifying the most significant features among the main attributes and making this knowledge accessible to Mongolians in urban areas is crucial. Geomantic knowledge is a vital skill that cannot be overlooked, even though it is becoming less recognized today.

Key words: *Geomancy, Mongolian literature in Tibetan, Buddhism*

1. Удиртгал

Орон хийдийн магтаал нь дэлхий дахины уран зохиолын нийтлэг түгээмэл төрөл зүйл боловч монголын уран зохиолд өөрийн гэсэн өнгө аястайгаар хөгжиж иржээ.

Монголчуудын төвөд хэлээр зохиосон орон, хийдийн магтаалыг уламжлалт сэтгэлгээний үүднээс өөрийн гэсэн өвөрмөц өнгө аястайгаар уламжлалт мэдлэг ухааныг шингээн хөгжүүлж ирсэн нь эх сурвалжуудаас харагдаж байна.

2. Үндсэн хэсэг

Орон хийдийн магтаал нь хэв маяг, ёс заншил, шашин шүтлэгээс хамааран харилцан адилгүй байдлаар зохиогдож ирсэн байх бөгөөд түүхэн хөгжлийн явцад хэлбэр, бүтэц, агуулгын хувьд баяжуулан хөгжүүлж иржээ.

Төвөд хэлээр зохиогдсон орон, хийдийн магтаал зохиолуудыг судлахын тулд Бурхны шашны магтаалын цоморлог нь “Магтаалын чуулган” /tib: bsdod

pi tsog/ нэртэйгээр хэвлэгдсэн Монгол Данжуурын нэгдүгээр боть, түүнээс гадна өөр бусад ботиудад буй магтаал зохиолуудыг үзэж судлах нь чухал юм. Энэхүү цоморлогт орон, хийдийн магтаалын шинжийг агуулсан хэд хэдэн зохиол байна.

Дорно дахины сав ертөнц, түүнд орших шимийн амьтдын хэрхэн үүссэн талаарх гүн дэлгэр ойлголтын талаар ловон (ажарьяа) Васубанду⁸⁶ (4th to 5th century C.E.)-гийн зохиосон “Илт номын гуу сан” буюу Абхидрхамакоша⁸⁷ зохиолын гуравдугаар бүлэгт сав ертөнц, шимийн амьтад хэмээх ойлголтын талаар өгүүлсэн байдаг. Энэтхэгийн ловон Васубанду-гийн зохиосон зохиолд Монгол, Төвөдийн номын мэргэдээс Пагва лам Лодойжанцан (1235-1280)-ы “Мэдэгдэхүүн машид тодруулсан шастир”, мөн Халх Брагри ёнзин Дамцагдоржийн (1781-1848) “Сав, шимийн үүсэх, орших, эвдрэх ёсыг үзүүлсэн шастир” зэрэг Абхидрхамакоша-г эш болгон тайлбар зохиолуудыг зохиосон байна. Дээрх номын мэргэдийн зохиолуудад орныг олон янзаар ангилан бичсэн байх бөгөөд тэдгээрт үндэслэн “орон” хэмээх ойлголтыг агуулгаар нь гадаад орон: Таван мэдрэхүйд мэдрэгдэж нүдэнд үзэгдэж гарт баригдаж газар орнууд, дотоод орон: учир шалтгааны үүднээс тухайн оронд зорчиж очиж үзэж болох газар орнууд, нууцын орон: самади бясалгал бүтээлийн арга замаар зорчих орон гэх байдлаар бүлэглэж хувааж болохоор байна.

Бидний ойлголтоор “орон”⁸⁸ хэмээх ойлголт нь өргөн утга агуулгатай нь харагдаж байна. Абхидрхамакоша болон түүний тайлбаруудад гарах орнуудын талаарх магтаал, ерөөлийн зохиол нь тусдаа судлагдах сэдэв хэмээн үзээд гадаад оронд хамаарах орон, хийдийн магтаалын зохиолд гарч буй газрын шинжийн талаар цаашид энэхүү өгүүлэлд дурдах болно.

Монголчууд эртнээс сав, шим ертөнцийн зүйлсийг танин мэдэх, шинжлэн судлах арга ухааныг хөгжүүлж ирсэн ба малын бэлчээр, өвөлжөө хаваржаа бууцны газраа шинжихээс гадна хот балгад босгох, сүм дуган, суварга шүтээн бүтээх зэрэгт газар орныг нягт нямбай шинжлэн үздэг ахуй, соёл, зан заншлаас үүдсэн баялаг уламжлалтай билээ.

Төвөд хэлээр зохиосон “Орон, хийдийн магтаал” зохиол нь агуулгын хувьд өргөн дэлгэр бөгөөд монгол магтаалын уламжлалт сэтгэлгээний хэв шинжийг агуулсан байдгийн нэг нь газар шинжих талаарх ойлголт юм.

Ардын аман зохиол “Жангарын тууль”-д “...нэгэн өдөр Замбалан хааны авхайг авч хатан суулгая гээд ...Тэр арван баатар нутаг үзэж ир хэмээн явуулахад арван баатар нь

Зуун голын эхээр гараад

⁸⁶ Vasubandhu

⁸⁷ Abhidharmakośa Sanskrit: अभिधर्मकोशभाष्य

⁸⁸ тө. ལནས gnas

Мянган голын адгаар гараад

Хүдэр Алтай гэдэг уулын

Өврийг шинжилж үзэв.

Тэр хөгшин зандан хөвөөлөөд ургасан

Залуу зандан захалж ургасан

Үнэг хэвтэх хонхоргүй

Үегүй цагаан дэрс ургасан

Хөхөл хүж үнэртсэн

Бурхан номын хүрээ болсон

Тийм газрыг үзэж иржээ”

хэмээн шинээр буудаллах газар орноо нягт нямбай шинжиж ирсэн уламжлалтайг тусган харуулжээ.

Ер нь газар шинжих мэдлэг ухаан нь иргэний аж байдлаас үүдэлтэй бөгөөд эртний Энэтхэг, Төвөд, Хятад зэрэг дорно дахины улс үндэстний эш ухаан, зан заншил, үзэл онол, сэтгэлгээ ойлголтуудтай холилдон бурхны шашны мэдлэг ухаан, бэлгэдэл зүйн үүднээс үлэмж баяжсаны дээр монголчууд өөрсдийн аж байдал, ахуй амьдралын онцлог, сэтгэлгээгээр баяжуулан хөгжүүлсэн байна.

Энд бид төвөд хэлээр орон, хийдийн магтаал зохиосон Эрдэнэ зуугийн номч цорж Лувсандагвадаржаа (1734-1803) “Богд дээд Занабазарын очирт хадан хорго Э Бам хийдийн магтаал хийгээд ерөөлийн үг Богд ламыг баясгагч тахилын үүл”, Хамба номун хан Агванхайдав (1779-1838)-ын зохиосон “Тутарга цогцолсон насан арвидах өлзийт орон, хийдийн магтаал”, Зава Дамдин гавж (1867-1937) “Дашдаржаалин хийдийн орны магтаал”, Дарва бандида Агванчойнжирдондүв (1870-1927) “Заяын хүрээний магтаал”-д гарах газрын шинжийн өгүүлэмжийн талаар танилцуулах юм.

Урьд хийд, орныг байгуулахдаа “10 буяны бэлгэ чанар дэлгэрсэн” газрыг сонгож байжээ. Эдгээр “Газрын шинжийн судар”-т “10 буян”-ыг сударт тэмдэглэхдээ:

Тө. khang sa zhing sa sa yi dge

thung chu yur chu chu yi dge

gam 'brog rgyang 'brog rtzwa yi dge

khang shing bud shing shing gi dge

khang rdo thab rdo rdo gnyi dge

мон: Байшингийн шороо, тариалангийн шороо (хоёрын) шорооны буян

Уух ус, татаал ус (хоёрын) усны буян

Ойрын хөдөө, холын хөдөө (хоёрын) өвсний буян

Байшингийн мод, түлшний мод, (хоёрын) модны буян

Байшингийн чулуу, тулганы чулуу (хоёрын) чулууны буян

гэжээ.

- Нэгдүгээрт, сүм хийд, хот балгадын дуган сүмийг барихад хэрэглэгдэх элс шороо, сүм хийд, хот балгадад амьдрагсдын тариалан эрхлэх үржил шимт хөрс шорооны хоёр зүйл буян;

- Хоёрт нь, оршин суух хүмүүсийн амны ус болоод тариа ногоог услах суурины дундуур татан авчирч болох татаал усны хоёр зүйл буян;

- Гуравт нь, ойрын хөдөө буюу хот балгадын дотор агч өвс ургамлын болон холын хөдөө аглагт агч өвс ургамлын хоёр зүйл буян;

- Дөрөвт нь, байшин барилгад хэрэглэгдэх мод болоод оршин суугч хүн зонд хэрэглэгдэх түлшний модны хоёр зүйл буян;

- Тавд нь, байшин барилгад ашиглах хад, чулуу болоод айл гэрт хэрэглэгдэх тулга голомт, тээрмийн чулууны хоёр зүйл буян;
гээд эдгээр арван зүйлийн буян жигдэрсэн бол арван буян дэлгэрсэн газар хот балгад, сүм хийд байгуулахад тохиромжтой хэмээн тэмдэглэсэн байна.

Үүнээс гадна уул ус, ургамал байгаль жигдэрч, нар сар гийсэн, нэг үгээр хэлбэл хөлд гишгэх газар, дээрээс тольдох тэнгэр нь тэгш хосолсон тийм орныг илүүтэйд үзэж, сонгон олж, сүм хийдээ байгуулж байжээ. Мөн ус голын тунгалаг, сэрүүн, хөнгөн, амттай, зөөлөн, бүлээн, хоолой хорлолгүй, ходоод гэдсэнд тустай байхыг чухалчилсан байна.

Газрын шинжийн судрууд тухайлбал, Төвөдийн Дэсрид Санжаажамцын зохиосон “Цагаан биндэрьяа” зохиолын газар шинжлэх 32-р бүлэгт Монголын II Дарва бандида Гунгаажамцын орчуулан нэмэлт хийсэн хувилбарт *“муу газрыг тэвчих түүний газрын гадаад, дотоод шинж, сайн газрыг авахуй түүний гадаад, дотоод шинж, эрхэм дээд газрын гадаад, дотоод шинж”* гэх зэргээр ангилж сүм хийд босгохдоо дээр дурдсан арван буян бүрдсэнээс гадна эрхэм дээд сайн шинжийг *“хаан төрийн долоон эрдэнэ”* болох *хүрдэн эрдэнэ, чандмань эрдэнэ, хатан эрдэнэ, түшмэл эрдэнэ, заан эрдэнэ, морин эрдэнэ, жанжин эрдэнэ, “Өлзийт найман тахил”* болох *их эрдэнийн шүхэр, хос загас, зөвшөөгөө эргэсэн номын цагаан лавай, өлзий утас, ялгуулсны их дуаз, эрдэнийн хумх, лянхуа цэцэг, алтан хүрд, “Дөрвөн хүчтэн”* болох *бар, арслан, гарди, луу* болон *“есөн эрдэнийн”* хэлбэр дүрс өнгө, эрдэм үйлсээр бэлгэдэн шинжилж орон, хийдийн магтаалдаа уран яруугаар дүрслэн өгүүлсэн байна.

Харин муу газрын шинжид, *сармагчин гараа ардаа хийсэн мэт, мангас харуулд гарсан мэт, буга даваан дээр гарсан мэт, чоно хяр дээр гарсан мэт* газар нь муу хэмээн шинжилдэг байна.

Монгол номын мэргэдийн төвөд хэлээр зохиосон орон, хийдийн магтаалд Эрдэнэ зуугийн номч цорж Лувсандагвадаржаа *“Богд дээд Занабазарын очирт хадан хорго Э Бам хийдийн магтаал хийгээд ерөөлийн үг Богд ламыг баясгагч тахилын үүл”* хэмээх магтаалд

“Бадмааргийн өнгөт Сүмбэр уул солонгоор хүрээлүүлсэн мэт их эрдэнийн хадан уулын оргил нь огторгуйг нөхөх адил

Орой нь тэгш бөгөөд зөөлөн нь их Агнистаг бэлгэднэ

*Олноор баясах ой, шугуй нэн үзэсгэлэнтэй нь тонилохуйн гурван үүдний
ялгамжаат хэлбэртэй” гэжээ.*

Энэхүү магтаал нь Төвхөн хийдийн орших уулын магтаал бөгөөд уулын шинжийг өгүүлэхдээ “Бадмааргийн өнгөт уул”, “Сүмбэр уул”, “Их эрдэнийн хадан уул” гэх зэргээр газрын дотоод шинжийн үүднээс магтан шүлэглэжээ.

“Бадмааргийн өнгөт” гэдэг нь Шивээт улаан уулын асга хад нь улаан боржин чулуун тогтоцтой бөгөөд нар шингэхэд Сүмбэр ууланд туссан туяа нь улбар шар өнгөтэй болж харагддаг ба тэрхүү өнгийг “бадмаараг” гэж нэрлэдэг гэдэг аж. Мөн Сүмбэр уул хэмээсэн нь Шивээт улаан уул нь далайн түвшнээс дээш 2600 м өндөрт орших бөгөөд тухайн газрынхаа эргэн тойрон дахь уулсаас харьцангуй өндөр нь учраас гадаад шинжийн үүднээс тодорхой магтан шүлэглэсэн байна. Харин эрхэм дээд газрын шинжийг агуулсан байдлыг өгүүлэхдээ “Орой нь тэгш бөгөөд зөөлөн нь их Агнистаг бэлгэднэ” гэж бурхны орны шинжийг агуулж байгааг тодорхой дүрсэлсэн бол өөр нэгэн бадагт

“Зүг завсар бүрд олон жижиг уулстай

долоон их эрдэнэ ба ойрын долоон эрдэнэ

Өлзийт найман тахил тэргүүтэн тахилын эдлэлийн дүрс

Самандабадрын ерөөлийн хүчээр бүтжээ, энд”

хэмээн хүрээлэн буй уулсыг хаан төрийн долоон эрдэнэ, ойрын долоон эрдэнэ, өлзийт найман тахил зэрэг эдүүд хүрээлэн оршиж буй нь өлзийт сайн газрын шинж бүрэлдсэнийг өгүүлжээ.

Мөн магтаалд Шивээт улаан уулын эргэн тойрон дахь шинж байдлыг дүрслэхдээ

“Нуур цөөрөм олон ба найман гишүүн төгөлдөр тахилын ус нь алгуур
бууж

Элдэв зүйлийн усны шувууд нь яруу дуугаа дуурьсган байнам

Үзэгдэх ба үл үзэгдэх цэцэгс алаглаад элдэв хүжсийн анхилам үнэр
анхилж

Өөрөө ургасан жимс ба рашаанууд нь гайхамшигтай”

гэсэн нь тухай газрыг дээр өгүүлсэн 10 буянт газрын зарим шинжүүд болох хол, ойрын хөдөө байх үзэмж сайт цэцэгс, сонор баясгах шувуудын дуу хангинасан байхын дээр найман гишүүн төгөлдөр ус бүхий рашаан гэх зэргээр шинж байдал цөм бүрдсэнийг магтсан байна. Мөн ямар ном бясалгаж бүтээвэл тустайг газрын шинжээр нь өгүүлэхдээ

“...хад асга нь догшин дүртэй

Агуй, нуга, зүлэг, булаг, ганц мод тэргүүт нь

жодва нарт машид өлзийтэй...”

гэсэн нь ганцаар аглагт зоригч жодва буюу дандрын ёсны “таслахын ёс”-ыг бясалгаачин нарт суух агуй, алхах нуга, жодгороо хатгах зүлэг, өдөр шөнийн

завсарт ном үйлдэх булаг, сондгойрон орших мод зэрэг зүйлүүд нь эрж хайн явах шаардлагагүй бүгд нэг дор оршин байгааг шинжлэн мэдээд “Өлзийтэй” газар хэмээжээ.

Харин хамба номун хан Агванхайдав (1779-1838)-ын “Тутарга цогцолсон насан арвидах өлзийт орон, хийдийн магтаал”⁸⁹ нь газрын шинж байдлыг дан бясалгал бүтээлийн үүднээс авч үзсэн нь бусад орон, хийдийн магтаалаас өвөрмөц болсон харагдаж байна. Балдан Брайбун хийдийн цогчин дуганыг анх байгуулахдаа зөрсөн чойнзон хэлбэртэй газрын гол төвд барьсан нь цэцгийн хонхорцог адил үлэмж үзэсгэлэнтэй, тухай газрыг улам бүр чимж тодруулан харагдаж байгааг шинжсэн магтаалд

“...Газар орон өөрөө гарсан чойнзонгийн хүйсэнд

Найман дэлбээт цагаан лянхуа хийдийн төвд

Тоорцгийн ёсоор цогцолсон их дуган...”

гэж газрын шинж байдлыг оруулан магтжээ. Харин арын уул нь өндөр нам гурван оройтой байх бөгөөд тэдгээрийн дандрын ёсны хөрөнгө “Э” үсгийн шинжтэй гэжээ.

Өмнөх Эрдэнэзуугийн номч цорж Лувсандагвадаржаа “Богд дээд Занабазарын очирт хадан хорго Э Бам хийдийн магтаал хийгээд ерөөлийн үг Богд ламыг баясагч тахилын үүл” хэмээх магтаалд хүрээлсэн уулсыг “долоон их эрдэнэ ба ойрын долоон эрдэнэ, өлзийт найман тахил”-ын шинжтэй гэж байсан бол харин Агванхайдав хамба

“Эргэн тойрон бүхэн нь уулаар хүрээлэгдсэн нь

Түүнд оршигч хуврагийн чуулган нь чанадаас эсэргүүцэгч язгууртныг

Ирэхийг хорихын тухайд номын сахиус цэргийн өмөг бээр

Бэлгэ билгүүний галын өмгийг тулцуулан хүрээлсэн мэт”

хэмээн хийд орноо эсрэгэлцэх өлзий бусын зүйлээс номын сахиус болоод цэргийн хүрээгээр хамгаалагдсан шинжтэй гэсэн нь бусад орон, хийдийн магтаалд өгүүлэх долоон их эрдэнэ, өлзийт найман тахил зэргийн шинжийг чухалчилсан байдлаас өөрөөр авч үзжээ.

Хамба номун хан Агванхайдавын зохиосон орон, хийдийн магтаал нь бусад монгол мэргэдийн зохиолоос нэлээд өвөрмөц бөгөөд бусад магтаалд гол, усыг найман гишүүн төгөлдөр гэж магтсан байдаг бол Агванхайдав бясалгал бүтээлийн аргын үүднээс энэхүү орон, хийдийн магтаалаа зохиосон учраас хийдийн хоёр талаар урсах голын шинжийг

“Баруун болон зүүн талаар хоёр голын ус мяралзаж

Рома, жанма цагаан, улаан хоёр махбод...” гэж дүрсэлжээ. Харин хийдийн урд орших нуурыг

“Лусын сан хөмрөг нээсэн адилын нуур

⁸⁹ тө. 'bras sbungs bkra shis tshe 'phel gling gi gnas bstod pa

Гэгээн сансрын өнгө дүрс ургасан толь

Түүнд орших хуврагийн чуулганд ном ба эд баялгийн

Баярын хуримд тахил тавиг усыг тусгайлан бэлдсэн” шинжтэй гэж газрын онцлог тогтоц зэргийг уран яруугаар бясалгалын аргыг шингээн нийлүүлж дүрсэлжээ.

Зава Дамдин гавжийн зохиосон Дашдаржаалин хийдийн магтаал “Хөхөөн яруу дуу” хэмээх орон хийдийн магтаалд “Газрын шинжийн судар”-т гардаг “арван буян” бүрдсэн газрын бэлгээр шинжлэн магтдаг байна. Дарба бандидын байгуулсан орон, хийдийн оршин байрласан газрын эрдмийг их сайны бэлгэ шинж зохион өгүүлсэн байдаг.

Дашдаржаалин хийдийн үүтгэн босгосон орон, газрыг хийдийн ард орших Булган уулын дээрээс харахад найман дэлбээт лянхуа цэцгийн хэлбэр төрхтэй, түүний гадуур хүрээлэн тойрсон их, бага уулсыг харахад, “өлзийт найман тэмдэг” цогцоороо бүрдсэн шинжтэйг өгүүлж, дээрх тэнгэрийг нь харахад доорх газрынхаа дугуй хүрээгээр л найман хигээст хүрдэн эрдэнээр бүрхэж бүтээсэн мэтийн байдалтайг утга бэлгэ, ур ухаан зохиож өгүүлсэн байна. Зава Дамдин гавж энэхүү байдлыг магтаалдаа

“Газар нь найман дэлбээт лянхуан дээр

Гадуур нь найман өлзийт тэмдгээр хүрээлсний

Гарч үзэгдэх дээр тэнгэр нь найман хигээст хүрднээр бүрхсэн адил

Газрын арван эрдэм төгс дэлгэр газар зүг

Орон хүрээ номын аймаг Дашдаржаалин хэмээх...” гэж магтсан байна.

VII Дарва бандида Агванчойнжирдондүв (1870-1927) “Заяын хүрээний магтаал”-д газрын сайн шинжүүдийг илүү тодруулан

“Булган уулын өмнө бэл нь

Нэн баттай алтан газар дэвсгэрийн дээр

Найман дэлбээ төгс лянхуа цэцэг

Нэвтэрхий гарч дэлгэрсэн дүр байдалтай” гэжээ.

Энэ магтаалаар магтаж байгаа хийдийнхээ хаана байрлаж буйг зохиогч тодорхой өгүүлсэн байх бөгөөд “Найман дэлбээ төгс лянхуа цэцэг” гэж төвөд хэлээр зохиогдсон орон, хийдийн магтаалд газрын шинжид нийтлэг байдлаар өгүүлдэг болох нь харагдаж байна.

Мөн огторгуйг нь шинжихдээ алтан хүрд эргэж байгаа байдалтай дүрсэлсэн нь Зава Дамдин гавжийн Дашдаржаалин хийдийн магтаалд мөн огторгуйг нь алтан хүрдний шинжтэй хэмээн магтсан байх бөгөөд

“Орны дээд огторгуйд нь

Найман хигээст хүрд орчино” гэсэн байна.

Энд найман хигээст хүрдээр эрхэм сайн газын шинжийг доод суурь болсон газар, дээд тэнгэр огторгуйд ч аль аль сайн шинжүүд бүрэлдсэнийг тодорхой өгүүлжээ. Энэхүү магтаалд,

Хоёр талаар гол мөрөн тойрч одон нийлэх нь
Арга билиг эрдэм ялгамжаатай хослон барилдахын шинж
Хойд уулын үргэлжлэл нь хөх луу баруун зүг ороосон нь
Номын цогцос 84000 хурахын шинж

Хад чулууны дүр байдлыг шинжид урвуулан арслан хэвтэж буй мэт гээд, эрдэнэ ачсан заан мэт, хөх луу ороосон мэт, алтан яст мэлхий давхарласан мэт гэх зэргээр дөрвөн хүчний шинж байдлаар зэргэлдээ орших толгод хад чулууг дүрсэлсэн байна.

“Хадан цохио зарим нэг нь улаан арслангийн шинжтэй тэрхүү шинжээр гаднын харшлах шалтгаан бүхэн гаргахгүй байхын шинжтэй гэж үзсэн бол, хойд уулын үргэлжлэл нь хөх луу баруун зүг ороосон нь Бурхан Шагжамунийн айлдвар номлолууд хуран чуулахын шинжийг агуулсан гэсэн бол, эд баялаг арвин байхын шинжид ойр тойрны зарим уулсыг эрдэнэ ачсан заан бэлчиж байгаа байдалт гэх зэргээр шинжсэн байна.


3. Дүгнэлт

Монголын төвөд хэлт уран зохиол дахь орон хийдийн магтаалд газрын шинжийн өгүүлэмжүүд нь бурхны шашны үүднээс сайн шинжүүдийг тодруулж, муу ёр бэлгийг эерүүлэн засаж бэлгэдлийн сайнаар магтсан байдаг нь дээрх жишээ болгон оруулсан эх сурвалжуудаас харагдаж байна. Газрыг шинжих шастирууд нь Энэтхэг, Хятад, Төвөд зэрэг орны хэлнээс орчуулан нүүдэлчин аж байдалд нийцүүлэн хөгжүүлж ирсэн болох нь харагдаж байна. Газрын шинжийг орон, хийдийн магтаалд өгүүлэмжийн хэлбэрээр оруулсан нь тухай газар орны эерэг энергийг арвидуулах, тухайн хийд, оронд суугч болоод сүсэглэх сүсэгтэн олны сэтгэлийг амарлиулах арга болгон өвөрмөц байдлаар хөгжүүлж иржээ хэмээн үзэж болохоор байна.

Ном зүй

- Дамдинсүрэн, Ц. (1976). *Монголын уран зохиолын тойм*. II дэвтэр, Улаанбаатар. (Damdinsuren, Ts. *Mongolyn uran zohiolyn toim* [Review of Mongolian Literature]. Volume II, Ulaanbaatar.)
- Дулам, С. (2004). *Дорно дахины уран зохиолын үүд*, Улаанбаатар, [Dulam, S. *Dorno dahiny uran zohiolyn üüd* [The gateway to Eastern literature]
- Гаадамба, М. (1958). *Утга зохиолын онолын товч*, Улаанбаатар, [Gaadamba, M. 1958. *Utga zohiolyn onolyn товч*. Ulaanbaatar [Literary theory brief]
- Хэл зохиолын хүрээлэн. (1968). *Жангар*. Улаанбаатар. [Khel zohiolyn хүрээлэн. 1968. *Jangar*. Ulaanbaatar.]
- Сүглэгмаа, Х. (2005). *Монголын уран зохиол дахь “Үг” зохиолын төрөл зүйл*. Улаанбаатар. [Suglegmaa, Kh. 2005. *Mongolyn uran zohiol dahi ug zohiolyn турал зүйл*. Ulaanbaatar. [Genres of “Word” in Mongolian Literature]

- Нямнягмар, Б.** (2021). *Газрын шинжийн шастур*. Улаанбаатар.
[Nyammyagmar, B. 2021. *Gazryn shinjyn sudar*. Ulaanbaatar (Shastra of Land Characteristics)]
- Хүрэлбаатар, Л.** *Алтан хүрдэн*. (1992). Хэвлэлд бэлтгэсэн Л.Хүрэлбаатар. Улаанбаатар, 20-р тал. [*Altan khurden*. Edited by L.Khurelbaatar] Golden wheel. 1992. Ulaanbaatar]
- Хүрэлбаатар, Л.** (2002). *Судар шастурын билиг*. [L.Khurelbaatar. 2002. *Sudar shastiryn bilig* [*Wisdom of sutra and shastra*] Ulaanbaatar]
- Хүрэлбаатар, Л.** (2008). *Огторгуйн цагаан гарди - 2*. [L.Khurelbaatar. 2008. *Ogtorguin tsagaan gardi – 2*. Ulaanbaatar]
- Jose Ignacio Cabezón., Roger R. Jackson.** (1997). *Tibetan literature Studies in genres*. Snow lion publication.,
- Maurice Winternitz.** (1985). *History of Indian Literature*. Volume 1, 2, 3. India.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.